МАГАДЛАГЧ ЭМЧ, МЭРГЭЖИЛТЭН Б.АМАРЖАРГАЛЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. "Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах" | | | | | | | |
| 1. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих | Зөвлөлийн хурлын шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцож, хяналт тавьж зөвлөмж өгсөн байна. | 47 удаа, 51 иргэн | Зөвлөлийн хуралд тогтмол оролцож, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьсан байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 46 удаагийн хуралд оролцож хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтыг зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нараар хянуулж, шинжилгээний бүрдэл дутуу, баталгаажилт хангалтгүй 48 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг түдгэлзүүлэх арга хэмжээ авав.<br><br>Зөвлөлийн хурлаар танилцуулга хийж буй эмчлэгч эмч нарт эпикриз бичилтийг сайжруулах талаарх зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна. Түүнчлэн 3 өрхийн эрүүл мэндийн төвд газрын даргын 329, 330, 331 тоот албан бичгээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлүүлэхэд анхаарах чиглэлээр зөвлөмж хүргүүлэв. | 2024.01.01-2024.12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь, хугацаа тогтоох үндэслэл, оношийн баталгаажилт хянах | Хянасан тоо | 3025 иргэн | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг онош нь бүрэн баталгаажсан иргэдэд тогтоосон байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар 2024 оны 12 сарын 05-ны байдлаар 2728 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.<br><br>Зөвлөлийн хурлын явцад холбогдох шинжилгээг давтан хийлгэх 11, өөрийн биеэр байлцуулан үзлэг хийх шаардлагатай 17 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгах асуудлыг түр түдгэлзүүлэв. | | |
| 3. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын дунд ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулах | Зохион байгуулсан тоо | 1 | Амбулаторийн картын бичилт, оношийн баталгаажилтын байдал сайжирсан байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж буй асуудлыг хянах явцад дахин үзлэг, шинжилгээ хийлгэх шаардлагатай 3 иргэнд сэтгэцийн болон дотрын төрөлжсөн мэргэжлийн ижил мэргэжилтний үзлэгийг хийлгэж, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгав. | 2024.01.01-2024.12.25 | |
| 4. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, холбогдох байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг тулган нягтлах, мэдээллийг шинэчлэх | Улирал тутам тулгасан байна. | Улирал тутам | Мэдээллийг тухай бүр шинэчилж, үнэн зөв мэдээлэл бүрдүүлсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 46 удаагийн хурлаар шийдвэрлэсэн нийт 2728 иргэний мэдээллийг үнэн, зөв бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллав.<br>Хяналтын явцад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, сунгалтын он сар өдөр, оношийн код, гэрийн хаяг, нэр, хүйс буруу 21, өвчний ангилал буруу 3 тохиолдолыг тус тус илрүүлж, залруулах арга хэмжээ авав.<br>Түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэврийн массивыг зөвлөлийн | 2024.01.01-2024.12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хурлын мэдээллийн сантай тулган шилжиж явсан 18, шилжиж ирсэн 7, нас барсан 64, халамжийн сангаас хугацаагүй сунгалттай тэтгэвэр авагч 2022 оноос дараа он руу шилжээгүй үлдсэн 2 иргэн, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил буруу 4 иргэний хөдөлгөөнийг тус тус засч бүртгэв.<br><br>Хурлын үед хийгдсэн хөдөлгөөний мэдээллийг тухай бүр хянаж Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн ehmkweb програмд файл илгээж байна. (46 удаа) | | |
| 5. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн тайлан мэдээнд судалгаа шинжилгээ хийх | Хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа хийсэн байна. | Хагас жил тутам | Зөвлөлийн тоон тайланд дүн шинжилгээ хийсэн байна. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтыг өмнөх оны байдалтай харьцуулахад 30 иргэнээр буюу 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br><br>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтыг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзэхэд жил бүр 2.43-2.82 хувиар тогтмол буурч байгаа боловч аймгийн нийт хүн амын тоонд харьцуулахад улсын дунджаас өндөр үзүүлэлттэй хэвээр байна. Аймгийн нийт хүн амын 4.4 хувийг хөдөлмөрийн чадвар алдсан иргэд эзэлж байна.<br><br>Хөдөлмөрийн чадвар алдалтын шинэ тогтоолтын 80 орчим хувийг дотрын өвчин (28.8%), хорт хавдар (21.9%), гэмтэл согогийн | 2024.01.01-2024.12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өвчин (10.7%), нүдний өвчин (9.0%), мэдрэлийн өвчин (8.1%) тус тус эзэлж байна.<br><br>Нийт сунгалтын 83.5 хувийг сэтгэц, дотор, гэмтэл согог, нүд, чих хамар хоолойн өвчин эмгэг эзэлж байна. | | |
| 6. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсвийг хуульд заасан хугацаанд боловсруулж, санал өгөх | Төсвийн төсөл, төсөөллийн санал өгсөн хугацаа | Жил бүрийн 6 дугаар сарын 20-ны дотор | Төсвийн төсөл, төсөөллийг үндэслэлтэй боловсруулсан байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсвийг Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн 10 дахь хэсгийн 10.1 дэх заалт, НДЕГ-ын газрын даргын 2024 оны А/72 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу тус тус тооцон 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийг боловсруулж заасан хугацаанд хүргүүлэв. | 2024.06.13-2024.06.17 | |
| 7. | Магадлалын төв зөвлөлөөс өгсөн хууль тогтоомжид нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх | Өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хугацаа | Тухай бүр | Төв зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байна. | Төв зөвлөлөөс үүрэг болгосон актын маягт, шийдвэрийн наалтын, зөвлөлийн гишүүдийн хурлын цагийн, шинээр томилогдсон гишүүдийн нийт 4 судалгааг тус тус гарган хугацаанд нь хүргүүлсэн.<br><br>Нугас булчингийн хатангирал өвчний эмнэлзүйтэй иргэдийн судалгааг гарган мэдээлэл ашиглах зөвшөөрлийг иргэдээс авч нэгтгэн ЭММТЗ-д хугацаанд нь хүргүүлэв. | 2024.01.01-2024.12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний заавart тусгах саналыг холбогдох эрүүл мэндийн байгууллагаас авч нэгтгэн хүргүүлэв.<br><br>Тус газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах гишүүдийн саналыг БОЭТ, ЭМГ, АЗДТГ, ХХҮГ-аас тус тус авч, нэгтгэн хүргүүлсэн болно.<br><br>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох ердийн өвчний жагсаалт шинэчлэгдэн батлагдсантай холбоотой Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс хуваарилсан өвчний ангилалын дагуу програмд оношийн код ӨОУА-ын ICD-10 кодоор зөв орсон эсэхийг тулган Дорноговь, Дундговь, Дархан аймгаас нэгтгэн авч, төв зөвлөлд хүргүүлэв. Сар бүрийн мэдээг тогтмол хүргүүлж ажиллав. | | |
| Зорилт 2. "Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах, хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудасны олголтод хяналт тавих, тайлагнах" | | | | | | | |
| 1. | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудасны бичилт, олголтод цахимаар хяналт тавих | Хянасан тоо | Тухай бүр | ЭМБ-аас даатгуулагчид олгосон эмнэлгийн хуудсыг шаардлагын дагуу зөв, хугацаандаа | Нийгмийн даатгалын шинэ систем portal.ndaatgal.mn сайтаар хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн хүсэлт илгээсэн 3369, ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн хүсэлт 97, жирэмсний болон амаржсаны | 2024.01.01-2024.12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бичигдсэн эсэхийг хянасан байна. | тэтгэмж авах хүсэлт 1561, нийт 5027 эмнэлгийн хуудасны бичилт, олголтыг sicos.ndaatgal.mn веб програмаар хянав.<br><br>Хяналтын явцад тэтгэмж авах эрх үүсээгүй, эмнэлгийн хуудас урьдчилж олгосон, ихэр төрөлт биш, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон оношоор эмнэлгийн хуудас олгогдсон, хугацаандаа хүсэлт гаргаагүй, үргэлжилсэн акт биш, тэтгэмж авах хугацаа давхацсан, өмнө нь шийдэгдсэн акт дахин илгээгдсэн, цэрэг цагдаагийн байгууллагын цолтой албан хаагч зэрэг шалтгааны улмаас 65 эмнэлгийн хуудсыг буцаах арга хэмжээ авав.<br>Мөн даатгуулагчийн арилжааны банкны дансны дугаарыг буруу илгээсэн нийт 114 хүсэлтийг буцааж, залруулан хүлээн авав. | | |
| 2. | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах | Сургалт, сурталчилгааны тоо | Тухай бүр | Сургалт, сурталчилгаа хийгдсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дотрын мэргэжилтэн хоол боловсруулах эрхтний эмгэгээс сэргийлэх дэлхийн өдрөөр нойр булчирхайн өөхжилт, оношилгоо, эмчилгээний менежментийн талаар 80 орчим эмч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.<br>Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн 110 бие бүрэлдэхүүнд “Зөв зохистой хооллолт” сэдвээр сургалт зохион байгууллаа. | 2024.01.01-2024.12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Чойбалсан хотын FM 89.1-д “Та элгээ гомдоосоор байх уу” сэдэвт олон нийтэд чиглэсэн ярилцлага өгсөн ба нийт 1000 орчим хүнд FM болон цахим сүлжээгээр хүрсэн байна.<br><br>“Тамхи таныг татна” сэдэвт сошиал контент бэлтгэн эрүүл мэндийн байгууллагын пэйж хуудсаар цацсан ба нийт 2200 орчим үзэлттэй, 50 орчим шэйр хийгдэж 10,000 орчим иргэдэд хүрсэн байна.<br><br>Дэлхийн зүрхний өдрөөр “Зүрхээ таньж зүрхээ хайрлая” сэдэвт сошиал контент бэлтгэн пэйж хуудсаар цацсан ба нийт 7500 орчим үзэлттэй, 40 орчим шэйр хийгдэж 12,000 орчим хүнд хүрсэн байна.<br><br>Дээрх арга хэмжээнд нийтдээ 23,000 гаруй эмч мэргэжилтэн, иргэд хамрагдсан байна.<br><br>Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”, Эрүүл мэнд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны А/441, А/192 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалт хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өвчний жагсаалт", Хөдөлмөр нийгмийн хамгаалал, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны А/177, А/433 дугаар тушаалаар баталсан "Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам"-ын талаарх мэдээллийг хүргэж, асуултад хариулав. Уг мэдээлэлд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 60 орчим эмч мэргэжилтэнүүд хамрагдлаа.<br><br>Түүнчлэн газрын даргын 10, 11, 15, 16 тоот албан бичгээр дээрх шинэчлэн батлагдсан дүрэм, журам, өвчний жагсаалтыг аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд хүргүүлэв. | | |
| 3. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадварыг сэргээн засах үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах | ЭМБ-уудтай хамтран ажилласан байна. | Тухай бүр | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон иргэдийн тоо өмнөх оны үеэс 2 хувиар буурсан байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдрэлийн их эмч эпилепси өвчтэй иргэд, тэдний ар гэр, асран хамгаалагч бүхий нийт 102 иргэнтэй уулзалт ярилцлага хийж, уг өвчний оношилгоо эмчилгээний талаарх шинэ мэдээлэл өгөв.<br><br>Эпилепси өвчний тухай гарын авлага, уналтын карт боловсруулж иргэдэд тараав. Энэхүү өдөрлөгт БОЭТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч захирал бөгөөд зөвлөлийн орлогч дарга, хүүхдийн мэдрэлийн, | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэтгэцийн, гэмтлийн эмч нар хамтран оролцсон.<br><br>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон иргэдийн тоо 3724 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | | |
| Зорилт 3. "Төрөөс нийгмийн даатгалын талаар баримталж буй бодлого, шийдвэрийг иргэдэд ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх" | | | | | | | |
| 1. | Нийгмийн даатгалын хууль, тогтоомж ач холбогдлыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчилах | Сургалт, сурталчилгаа, мэдээллийн тоо | Тухай бүр | Иргэд даатгуулагчдад эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомж, эмнэлгийн хуудас бичилт, олголтын чиглэлээр мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан байна. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолт, эмнэлгийн хуудас бичилт, олголт, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны болон жирэмсэн амаржсаны тэтгэмж, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, сайн дурын даатгал, нийгмийн даатгалын гар утасны аппликейшны талаар утсаар болон биечлэн ирсэн нийт 1936 гаруй даатгуулагч (иргэн)-д мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.<br><br>Түүнчлэн БОЭТ, Асралт үйлс, Мянган жаргалан, Ягаан цээнэ өрхийн эрүүл мэндийн төвийн 80 гаруй эмч мэргэжилтэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолт, эмнэлгийн хуудас олгох журмын талаар мэдээлэл хүргэв. | 2024.01.01-2024.12.25 | |
| 2. | Нийгмийн даатгалын гар утасны аппликейшн хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх | Аппликейшнд хамрагдсан даатгуулагчдын тоо | - | Нийгмийн даатгалын аппликейшний талаарх мэдээллийг даатгуулагч | Нийгмийн даатгалын гар утасны аппликейшны талаар 45 даатгуулагчдад мэдээлэл өгч, 5 даатгуулагчийн бүртгэлийг шинээр баталгаажуулж, бүртгэлтэй 15 даатгуулагчийн | 2024.01.01-2024.12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | иргэдэд өгсөн байна. | мэйл хаяг, утасны дугаарыг шинэчлэн засав. | | |
| Зорилт 4. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" | | | | | | | |
| 1. | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, тушаал, шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Төлөвлөгөө, тайлан, мэдээний тоо | Тухай бүр | Тайлан мэдээг хугацаанд нь чанартай гаргаж тайлагнасан байна. | Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд 2023 оны жилийн эцэс, 2024 оны хагас жилийн тоон болон бичмэл тайлан, зөвлөлийн хурлын цагийн бүртгэлийн, маягтын зарцуулалтын тайлангуудыг тус тус гаргаж хугацаанд нь хүргүүлэв.<br><br>Төрийн албан хаагчийн 2024 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд В үнэлгээ авсан.<br><br>Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүргийн дагуу 5 судалгаа, Аймгийн Засаг даргын тамгын газарт 15-34 насны хөгжлийн бэрхшээлтэй 672 иргэдийн судалгааг хавсралт маягтын дагуу, Эрүүл мэндийн газарт тархины саажилт, уналт таталттай 16-19 насны иргэдийн судалгаа, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дотрын нарийн мэргэжлийн эмчид элэгний хатуурал өвчний заалтаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн судалгаа нийт 12 мэдээ, судалгааг тус тус гарган хүргүүлээд байна. | 2024.01.01-2024.12.25 | |
| 2. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн | Зөрчилгүй ажилласан байна. | Тухай бүр | Хууль тогтоомж, журмыг мөрдлөг | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын | 2024.01.01-2024.12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Мэдэгдэл, тайлбар гаргасан тоо. | | болгон ажилласан байна. | зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гарган, холбогдох мэргэжилтэнд баталгааны маягтыг хүлээлгэн өгөв.<br><br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2023 оны жилийн эцсийн тайлан, хурлын тэмдэглэл, цагийн бүртгэл, зөвлөлийн бүртгэл болон зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарын гэрээний биелэлттэй холбоотой баримт бичгүүдийг архивлан нэгж үүсгэж 1 ботийг архивт хүлээлгэн өгөв.<br><br>Албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу 20 албан бичиг төлөвлөж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.<br><br>Халхгол сумын иргэн Ц.Чулуунбилэгээс ирсэн өргөдлийг судалж (хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан тухай) хариуг хуулийн хугацаанд албан бичгээр өгөв.<br>НДЕГ-ын даргын 01/165 тоот албан бичгээр ирсэн иргэн Н.Булгамаатай холбоотой ХЧА-ын хувь, хугацаа тогтоолтын талаарх мэдээллийг тухайн иргэнтэй холбогдож нарийн мэргэжлийн эмчдээ үзүүлж хурлаар орохыг утсаар мэдэгдсэн | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | болovч иргэн өөрөө эмчдээ хандаагүй тул шийдвэрлээгүй болно. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жилийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх | Даатгуулсан ААНБ, даатгуулагчийн тоо | 2 | Даатгалын ач холбогдлын талаар мэдээлэл өгч, хамруулсан байна. | Сайн дурын даатгалын талаар 150 гаруй даатгуулагч, иргэнд мэдээлэл өгч, цахимаар хэрхэн гэрээ байгуулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөв.<br>Нийгмийн даатгалд шинээр эм, эмнэлгийн хэрэгслийн үйл ажиллагаа эрхэлдэг Дорно талын тун ХХК (3 даатгуулагчтай) 1, 0-3 насны хүүхдээ асарч буй 2 эх, малчны сайн дурын даатгалд 2, энгийн сайн дурын даатгалд 7, нийт 11 иргэнийг сайн дурын даатгалд хамрууллаа. | 2024.01.01-2024.12.25. | |
| 2. | Удирдлагаас өгсөн үүргийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бууруулах | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага буурсан хувь, хэмжээ | Тухай бүр | Хуваарилж өгсөн аж ахуйн нэгж байгууллагатай холбогдож авлага бууруулсан байна. | Газрын даргын баталсан “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, авлага бууруулах аян”-ы удирдамжийн дагуу 2 дугаар багт хуваарилагдан нийт 65 аж ахуйн нэгж байгууллагын 386.4 сая төгрөгийн авлага барагдуулахаар (2024 оны 05 дугаар сарын 15-наас 06 дугаар сарын 30-ныг хүртэл) ажиллав.<br><br>Манай баг уг авлага барагдуулахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтын дагуу дараах арга хэмжээг авав. Үүнд: | 2024.01.01-2024.12.25. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Шимтгэлийн өрийг тухайн сардаа багтаан төлөхийг сануулж 26 аж ахуйн нэгж байгууллагын 86.4 сая төгрөг;<br>• Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж 16 аж ахуйн нэгж байгууллагын 197.1 сая төгрөг;<br>• Шимтгэлийн өртэй ажил олгогчийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг зогсоож 4 байгууллагын 31.9 сая төгрөг, нийт 315.4 сая төгрөгийн авлага барагдуулсан байна.<br>Мөн багуудад дахин шинээр хуваарилсан 54 аж ахуйн нэгж байгууллагын 469.8 сая төгрөгийн авлагаас 27 аж ахуйн нэгж байгууллагын 69.2 сая төгрөгийн авлага барагдуулж ажиллав. | | |
| 3. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн зүүн бүсийн сургалт зохион байгуулах | Сургалтад хамрагдсан оролцогсдын тоо | - | Зүүн бүсийн сургалтад холбогдох эмч мэргэжилтнүүд хамрагдаж, мэдээлэл авсан байна. | ГБХНХЯам, ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, НДЕГ-ын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлтэй хамтран Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход оролцож буй анхан шатны эмч нарыг чадавхжуулах нь" сэдэвт зүүн бүсийн сургалт 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр манай аймагт зохион байгуулагдав.<br><br>Уг сургалтад Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, Дорнод аймгийн БОЭТ, Асралт үйлс, Мянган жаргалан, | 2024.10.08-2024.10.09 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ягаан цээнэ өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 35 эмч мэргэжилтнүүд хамрагдлаа.<br><br>ГБХНХЯам, ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, НДЕГ-ын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс эрүүл мэндийн магадлалын бодлого, үйл ажиллагаа, хөдөлмөрийн чадвар алдалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар болон зонхилон тохиолдож буй дотор, сэтгэц, нүд, чих хамар хоолой, мэдрэлийн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход анхаарах асуудал, оношийн баталгаажилт, хяналт сэдвээр сургалтад оролцогчдод хичээл зааж, мэдээлэл өгөв. | | |
| 4. | Команд штаб сургуулилтад оролцох | Өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэсэн байна. | - | Сургуулилтад идэвхтэй оролцож, мэдлэгтэй болсон байна. | ГБХНХЯам Онцгой байдлын ерөнхий газартай хамтран салбарын хэмжээнд "Команд штаб сургууль" 2024 оны 11 сард зохион байгуулагдав.<br>Уг үйл ажиллагаанд НДГ-ын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн байгуулах тушаалын төсөл боловсруулж, ЭММТЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу зөвлөлийн гишүүдийг ZOOM уулзалтад хамруулж, команд штаб сургуулийн үед Төв зөвлөлөөс ирсэн 2 албан тоотын хариуг хугацаанд нь өгч ажиллав. Сургуулилтын үед зарлан мэдээ дохио 2 удаа ирсэн ба схемийн дагуу шуурхай мэдээ дамжуулж ажиллалаа. | 2024.11.11-2024.11.12 | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Монгол бичгийн ур чадварыг сайжруулах | Сургалтад хамрагдсан тоо | - | Богино хугацааны сургалтад хамрагдсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулж буй монгол бичгийн дунд шатны онлайн сургалтын 5 хичээлд хамрагдсан. Түүнчлэн "монгол бичиг" пейж хуудсанд нэгдэж монгол бичгийн уншлагаа сайжруулж байна. | 2024.01.01-2024.12.25. | |
| 2. | Сургалт болон бусад нэгдсэн арга хэмжээнд оролцож мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх | Сургалтад хамрагдсан тоо | 16 | Сургалтад хамрагдсан байна. | Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс цахимаар зохион байгуулсан 3 удаагийн уулзалтад хамрагдав. *(зөвлөлийн тайлан гаргах, шинэ програм нэвтрүүлэхтэй холбоотой, эмнэлгийн хуудас олгох журам шинэчлэн батлагдсантай холбоотой орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч мэргэжилтнүүдийн хамт, зөвлөлийн нарийн бичгийн даргын хамт)*<br><br>Хамрагдсан сургалтууд:<br>✓ Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар "Байгууллага хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага", "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-II", "Төрийн албаны үнэт зүйл, үе хоорондын ялгаатай байдал", сэдэвт 3 удаагийн сургалтад;<br>✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас зохион байгуулсан "Үйлдлийн олон улсын ангилалд суурилан хөгжлийн | 2024.01.01-2024.12.25. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх чадварт үнэлгээ хийх арга хэрэгсэл” сэдэвт сургалтад танхимаар 3 хоног;<br>✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллах арга зүй” сургалтад тэтгэврийн байцаагч Б.Цэцэгдэлгэрийн хамт танхимаар;<br>✓ НДЕГ-аас цахимаар зохион байгуулсан “Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр комиссар Р.Төрбулаг, “Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт” сэдвээр комиссар М.Жамъяачойжил нарын сургалтад 1 удаа;<br>✓ Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад хамрагдах албан хаагчдад зориулсан цахим сургалтад тус тус хамрагдав.<br>Нийт 10 удаагийн уулзалт, сургалтад хамрагдлаа.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай” 2024 оны А/177 дугаар тушаалын дагуу нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, сэргээх, баталгаажуулах шалгалтад орж тэнцсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх чадварт үнэлгээ хийх арга хэрэгсэл” сэдэвт сургалтад танхимаар 3 хоног;<br>✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллах арга зүй” сургалтад тэтгэврийн байцаагч Б.Цэцэгдэлгэрийн хамт танхимаар;<br>✓ НДЕГ-аас цахимаар зохион байгуулсан “Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр комиссар Р.Төрбулаг, “Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт” сэдвээр комиссар М.Жамъяачойжил нарын сургалтад 1 удаа;<br>✓ Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад хамрагдах албан хаагчдад зориулсан цахим сургалтад тус тус хамрагдав.<br>Нийт 10 удаагийн уулзалт, сургалтад хамрагдлаа.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай” 2024 оны А/177 дугаар тушаалын дагуу нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, сэргээх, баталгаажуулах шалгалтад орж тэнцсэн. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| Магадлагч эмч, мэргэжилтэн | Б.Амаржаргал ( ) | 2024.' |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Ог* |